



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан



Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.

Аймаг, нийслэлийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл, түүнчлэн нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор	Товчилсон үгийн тайлал	4
М.Батсуурь	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
Аудитын менежер	Бүлэг 1. Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан уу.	7
М.Бат-Амгалан	1.1. Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.	7
Ахлах аудитор	1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.	7-8
Ч.Мөнхтогтох		8-9
Аудитор	Бүлэг 2. Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж 42,718.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	10
Т.Золоо		10-13
А.Нанжидмаа	2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 42,718.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	13-14
2024 оны 11 дүгээр сар	2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.	14
	2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.	15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.	Дүгнэлт	16
	Холбогдох байгууллагын санал	17
Хаяг:	Аудитын газраас өгөх тайлбар	17
Увс аймаг дахь Төрийн Аудитын газар		
Улаангом сум 3 баг		
аймгийн Засаг даргын тамгын газрын байр		

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГНАГ	Гүйцэтгэл нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10, 10.11 дэх хэсгийг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх;

Хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороод, Увс аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсийг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын төлөвлөгөө, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу батлагдсан хөтөлбөрийн хүрээнд аудитыг хийж баталгаажуулсан.

Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Төрийн аудитын тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТатварын тухай хууль
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд

Үндсэн мэдээлэл:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийг аймгийн 30 тойрог 35 мандат, 19 сумын 94 тойрог, 399 мандат, нийт 434 мандаттай, аймгийн 1 хороо, сумын 19 хороо, 94 хэсгийн хороотойгоор зохион байгуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс Увс аймгийн Сонгуулийн хороонд 1,076,736.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

**БҮЛЭГ: 1. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд
улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд
заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.****1.1. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1-д “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна” гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 3/940 дугаар албан бичгээр Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санхүүжилтийн хуваарийг гаргаж Увс аймгийн Сонгуулийн хороонд 1,076,736.3 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Журмын 2.2-д “Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардал хуваарилна” гэж заасны дагуу дараах байдлаар хуваарилж ирүүлсэн байна. Үүнд:

			/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв	
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх	1,385.0	
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	18,477.1	
3	МТБ, даамлын сургалт	24,158.1	
4	Бичиг хэрэг	15,130.0	
5	Шуудан холбоо	18,450.0	
6	Унаа	77,560.0	
7	Санал авах байр бэлтгэх	26,320.0	
8	Сурталчилгаа	20,000.0	
9	МТБ-ийн гишүүний холбоо, унаа	1,300.0	
10	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолт	59,690.0	
11	Томилолт	19,455.3	
12	Сүлжээний судалгаа хийх	1,917.0	
13	Саналын хуудас устгах	449.0	
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах	8,820.0	
15	Санал авах байрны түлш	9,450.0	
16	Сурталчилгааны материал тараах унаа	13,160.0	
17	Шуурхай баг	3,200.0	
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол	646,732.8	
19	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоол	100,576.0	
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	2,610.0	
21	Болзошгүй зардал	7,896.0	
	ДҮН	1,076,736.3	

/Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын тушаал/

Журмын 2.3-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар, аргачлал, байгуулагдсан сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах байдлаар хуваарилна” гэж заасны дагуу

Увс аймгийн Сонгуулийн хорооны даргын “Санхүүжилт хуваарилах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 06, 09 дүгээр сарын 18-ны өдрийн 07, 10 дугаар сарын 02-ны өдрийн өдрийн 08, 10 дугаар сарын 10-ны өдрийн 09 дүгээр захирамжуудаар тус тус хуваарилсан байна. Үүнд:

/мян.төг/

№	Сумдын нэрс	Санал авах байр тохижуулах зардал	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал	Сурталчилгааны материал тараах унааны зардал	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглах зардал	Санал авах байрны түлшний зардал	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал	Хоол	НДШ	Сурталчилгааны зардал	Нийт
1	Баруунтуруун	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	26,820.0	2,800.0	3,218.4	500.0	40,198.4
2	Бөхмөрөн	570.0	510.0	600.0	2,590.0	420.0	280.0	300.0	21,540.0	2,240.0	2,584.8	500.0	32,134.8
3	Давст	570.0	510.0	600.0	2,590.0	420.0	280.0	300.0	21,540.0	2,240.0	2,584.8	500.0	32,134.8
4	Завхан	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	25,380.0	2,660.0	3,045.6	500.0	38,445.6
5	Зүүнговь	950.0	750.0	900.0	3,990.0	700.0	560.0	600.0	30,660.0	3,220.0	3,679.2	500.0	46,509.2
6	Зүүнхангай	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	25,380.0	2,660.0	3,045.6	500.0	38,445.6
7	Малчин	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	25,380.0	2,660.0	3,045.6	500.0	38,445.6
8	Наранбулаг	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	26,820.0	2,800.0	3,218.4	500.0	40,198.4
9	Өлгий	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	26,820.0	2,800.0	3,218.4	500.0	40,198.4
10	Өмнөговь	950.0	750.0	900.0	3,990.0	700.0	560.0	600.0	30,660.0	3,220.0	3,679.2	500.0	46,509.2
11	Өндөрхангай	950.0	750.0	900.0	3,990.0	700.0	560.0	600.0	30,660.0	3,220.0	3,679.2	500.0	46,509.2
12	Сагил	950.0	750.0	900.0	3,990.0	700.0	560.0	600.0	30,660.0	3,220.0	3,679.2	500.0	46,509.2
13	Тариалан	1,140.0	870.0	1,050.0	4,690.0	840.0	700.0	750.0	37,380.0	3,920.0	4,485.6	500.0	56,325.6
14	Түргэн	570.0	510.0	600.0	2,590.0	420.0	280.0	300.0	21,540.0	2,240.0	2,584.8	500.0	32,134.8
15	Тэс	1,900.0	1,350.0	1,650.0	7,490.0	1,400.0	1,260.0	1,350.0	58,500.0	6,160.0	7,020.0	500.0	88,580.0
16	Ховд	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	25,380.0	2,660.0	3,045.6	500.0	38,445.6
17	Хяргас	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	25,380.0	2,660.0	3,045.6	500.0	38,445.6
18	Цагаанхайрхан	760.0	630.0	750.0	3,290.0	560.0	420.0	450.0	25,380.0	2,660.0	3,045.6	500.0	38,445.6
19	Улаангом	2,470.0	1,710.0	2,100.0	9,590.0	1,820.0			75,660.0	7,980.0	9,079.2	500.0	110,909.2
	Нийт	17,860.0	14,130.0	16,950.0	75,110.0	13,160.0	8,820.0	9,450.0	591,540.0	62,020.0	70,984.8	9,500.0	889,524.8

/Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны даргын захирамж /

1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

10.2.1.сонгогчийг бүртгэх, түүнийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, тээвэрлэх, даатгал хийлгэх зардал, лицензийн төлбөр;

10.2.2.сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байршуулах, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;

10.2.3.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, холбоо, унаа, томилолтын зардал;

10.2.4.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;

10.2.5.сонгогчийг бүртгэх техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын ажилтны томилолт, унааны зардал, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий мэдээллийн технологийн шуурхай багийн ажилтны мөнгөн урамшуулал, хоолны зардал;

10.2.6.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;

10.2.7.сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал.

Дээрх заалтын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 дугаар тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын төсөв”-ийг баталсан байна. Үүнд:

		/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унаа	54,945.00
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардал	3,895.70
3	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл, программ хангамж худалдан авах	2,140.00
4	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад	16,732.00
5	Сонгогчдын бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	9,436.00
6	Сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах бусад	1,881.00
	ДҮН	89,029.70

/Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал/

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

10.3.1.саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх үеийн хамгаалалт, санал авах байр болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах, дүн дамжуулах үеийн хамгаалалт, техник хэрэгсэл, шатахууны зардал;

10.3.2.цагдаагийн алба хаагчийн томилолт, унаа, мөнгөн урамшуулал, хоолны зардал.

Дээрх заалтын дагуу Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албаны 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 16/3171 дүгээр албан бичгээр “Аймаг, нийслэл, сум, дүүргийн 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсөв”-ийг хуваарилсан байна. Үүнд:

		/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Хоол	24,936.0
2	Шуудан холбоо	10,770.0
3	Дотоод албан томилолт	6,700.0
4	Шатахуун	3,000.0
	ДҮН	45,406.0

/Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын албан бичиг/

БҮЛЭГ: 2. Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж 42,718.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 42,718.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилсан төсвийн зарцуулалтыг зардлын зүйл ангиллаар харуулбал дараах байдалтай байна.

/мян. төг/

№	Зардлын нэр	Аймгийн нийт дүнгээр		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,385.0	100.0	1,285.0
2	Сургалтын зардал	18,477.2	15,778.5	2,698.8
3	МТБ, даамлын сургалтын зардал	24,158.1	21,928.5	2,229.6
4	Бичиг хэргийн зардал	15,130.0	15,122.9	7.1
5	Шуудан холбооны зардал	18,450.0	17,850.0	600.0
6	Унааны зардал	77,560.0	77,270.5	289.5
7	Санал авах байр бэлтгэх зардал	26,320.0	26,320.0	-
8	Сурталчилгааны зардал	20,000.0	18,991.2	1,008.8
9	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолтын зардал	59,690.0	41,037.0	18,653.0
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	250.0	1,050.0
11	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	8,820.0	8,540.0	280.0
12	Шуурхай багийн зардал	3,200.0	3,200.0	-
13	Томилолтын зардал	19,455.2	15,449.2	4,006.1
14	Сүлжээний судалгаа хийх зардал	1,917.0	1,917.0	-
15	Саналын хуудас устгах зардал	449.0	-	449.0
16	Санал авах байрны түлшний зардал	9,450.0	9,150.0	300.0
17	Сурталчилгааны материал тараах унааны зардал	13,160.0	13,160.0	-
18	Болзошгүй зардал	7,896.0	7,067.2	828.8
19	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	646,732.8	640,969.2	5,763.7
20	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоол, НДШ	100,576.0	97,763.7	2,812.4
22	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	2,610.0	2,153.0	457.0
	Зарцуулалтын дүн	1,076,736.3	1,034,017.7	42,718.6
	Сум төвлөрүүлсэн орлого		2,585.5	(2,585.5)
	Аймаг төвлөрүүлсэн орлого		40,133.1	(40,133.1)

/Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт "Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ" гэж заасныг зөрчин Бөхмөрөн сумын сонгуулийн хороо

нь хорооны гишүүд, хэсгийн хорооны гишүүд, техникийн даамал нийт 32 хүнд 21,540.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татварын 640.3 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн, хоолны зардал олгохдоо 224.0 мянган төгрөгийн татварыг суутгаагүй байна. Түргэн сумын сонгуулийн хороо нь сонгуулийн хорооны гишүүд, хэсгийн хорооны гишүүд техникийн даамал нийт 38 хүнд хоолны зардал олгохдоо 112.0 мянган төгрөгийн татвар дутуу суутгасан нийт 980.3 мянган төгрөг байна.

Аудитын явцад дээрх дутуу суутгасан 976.3 мянган төгрөгийн татварын суутгалыг сумдын орон нутгийн татварын дансанд төвлөрүүллээ.

Мөн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Энэ хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод доор дурдсан хувиар тооцож, албан татвар ногдуулна”, 21.2.4 дэх заалтад “Энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар” гэж заасныг зөрчин Хяргас сумын сонгуулийн хороо нь хувь хүнээс худалдан авалт хийхдээ төлбөрийн даалгавар үүсгэхгүйгээр 5,720.0 мянга, Өлгий сумын сонгуулийн хороо 450.0 мянга, Өмнөговь сумын сонгуулийн хороо 1,660.0 мянга, нийт 7,830.0 мянган төгрөгийн шилжүүлэг хийсэн байна.

Дээрх 3 сумдын 7,830.0 мянган төгрөгийн төлбөрийн даалгавар үүсгүүлж аудитын явцад залруулга хийлгэлээ.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А/136 дугаар тушаалын хавсралтаар 89,029.7 мянган төгрөгийг итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унаа, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх, түүнийг хүргэх тээврийн зардал, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл, программ хангамж худалдан авах, сургалт зохион байгуулах, техник хэрэгслийг тээвэрлэх болон хэвийн ажиллагааг хангах шуурхай багийн зардал, сонгууль зохион байгуулахдаа холбогдон гарах бусад зардалд захиран зарцуулах эрхийг Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсныг дараах байдлаар зарцуулсан байна.

Зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна

				/мян.төг/
№	Зардал	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны цалин	54,945.0	54,857.6	87.4
2	Бичиг хэрэг	3,895.7	3,895.7	-
3	Сонгуулийн хэсгийн хороодод техник хэрэгсэл хүргэх зардал	2,140.0	2,140.0	-
4	Унаа, томилолт	16,831.0	16,837.5	-6.5
5	Сургалт	1,782.0	1,782.0	-
6	Шуурхай багийн томилолт	1,436.0	1,436.0	-
7	Тээвэр	8,000.0	8,000.0	-
Нийт дүн		89,029.7	88,948.8	80.9

/Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн баримт/

Дээрх хүснэгтээс харахад Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан 89,029.7 мянган төгрөгийн зардлаас итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны цалинд 54,857.6 мянга, бичиг хэргийн зардалд 3,895.7 мянга, сонгуулийн

хэсгийн хороодод техник хэрэгсэл хүргэх зардалд 2,140.0 мянга, томилолт унааны зардалд 16,837.5 мянга, сургалтын зардалд 1,782.0 мянга, шуурхай багийн томилолтын зардал 1,436.0 мянга, тээврийн зардалд 8,000.0 мянга, нийт 88,948.8 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 80.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 48/3719 дугаар тушаалаар 45,406.0 мянган төгрөгийг санал авах байрны хамгаалалт, дотоод албан томилолт, тээвэр шатахуун, цагдаагийн албан хаагчийн холбоо, хоолны зардалд захиран зарцуулах эрхийг Увс аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн байна. Хуваарилсан зардлыг батлагдсан төсвийн дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах байрны хамгаалалтад ажилласан 93, саналын хуудас, санал авах төхөөрөмж хадгалах байрны хамгаалалтад ажилласан 3, гэмт хэрэг, зөрчил гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх алба хаагч 11, сонгуулийн үйл ажиллагааны үед эргүүлд ажиллах албан хаагч 20, шуурхай штабт ажиллах албан хаагч 7, санал авах байранд нэмэлтээр ажиллуулах албан хаагч 8, замын хөдөлгөөн зохицуулалтад ажилласан албан хаагч 19, бусад томилгоот 18, нийт 179 албан хаагчдын томилолт, хоол, шуудан холбоо, унааны зардалд зарцуулсан байна.

Увс аймгийн хэмжээнд 20 сонгуулийн хороо, 94 хэсгийн хорооны санал авах байрны хамгаалалтад нийт 94 алба хаагчдыг томилон, 20 алба хаагчийг нөөцөөр ажиллуулсан байна.

Зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна

		/мян.төг/			
Д/д	Зардал	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	
1	Хоол	24,936.00	24,936.00	0.00	
2	Шуудан холбоо	10,770.00	10,770.00	0.00	
3	Дотоод албан томилолт	6,700.00	6,700.00	0.00	
4	Шатахуун	3,000.00	3,000.00	0.00	
	Нийт дүн	45,406.00	45,406.00	0.00	

/Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, Увс аймгийн Цагдаагийн газрын санхүүгийн баримт/

Батлагдсан санхүүжилтээс хоолны зардалд 24,936.0 мянга, шуудан холбооны зардалд 10,770.0 мянга, шатахууны зардалд 3,000.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 6,700.0 мянга, нийт 45,406.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.4-д “Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нягтлан бодогч нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд тус тус хүлээлгэн өгнө” гэж заасан байна.

Мөн журмын 4.5-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулсан байна” гэж заасан байна.

Сонгуулийн хорооны ирүүлсэн төлөвлөгөө гүйцэтгэл дараах байдалтай байна.

					/мян.төг/
Д/д	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Баруунтуруун	40,198.4	40,198.4	0.0	
2	Бөхмөрөн	32,134.8	32,134.8	0.0	
3	Давст	32,134.8	32,108.4	26.4	
4	Завхан	38,445.6	38,445.6	0.0	
5	Зүүнговь	46,509.2	46,509.2	0.0	
6	Зүүнхангай	38,445.6	38,445.6	0.0	
7	Малчин	38,445.6	38,445.6	0.0	
8	Наранбулаг	40,198.4	40,198.4	0.0	
9	Өлгий	40,198.4	40,160.5	37.8	
10	Өмнөговь	46,509.2	46,509.2	0.0	
11	Өндөрхангай	46,509.2	46,509.2	0.0	
12	Сагил	46,509.2	45,747.3	761.9	
13	Тариалан	56,325.6	56,325.6	0.0	
14	Түргэн	32,134.8	31,274.8	860.0	
15	Тэс	88,580.0	88,580	0.0	
16	Ховд	38,445.6	38,355.4	90.2	
17	Хяргас	38,445.6	38,445.6	0.0	
18	Цагаанхайрхан	38,445.6	38,445.6	0.0	
19	Улаангом	110,909.2	110,100.0	809.2	
20	Аймаг	187,211.5	147,078.4	40,133.1	
	Нийт дүн	1,076,736.3	1,034,017.6	42,718.6	

/Эх сурвалж: аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.9-д “Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хороо 40,133.1 мянган төгрөг, Давст сумын сонгуулийн хороо 26.4 мянга, Өлгий сумын сонгуулийн хороо 37.8 мянга, Өндөрхангай сумын сонгуулийн хороо 761.9 мянга, Түргэн сумын сонгуулийн хороо 860.0 мянга, Ховд сумын сонгуулийн хороо 90.2 мянга, Улаангом сумын сонгуулийн хороо 809.2 мянга, нийт 42,718.6 мянган төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10-д Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь сум дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

Гэтэл Аймаг, сумдын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

Цаашид сонгуулийн зардлын зарцуулалтад журамд заасны дагуу шат шатны хяналт тавьж ажиллахыг зөвлөв.

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг сонгуулийн зардлын санхүүжилт олгох бүрд дараах албан бичгүүдээр ирүүлсэн байна. Үүнд:

- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 3/777 дугаар албан бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 3/834 дүгээр албан бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 3/852 дугаар албан бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 3/909 дүгээр албан бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 3/940 дүгээр албан бичиг

Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг сонгуулийн зардлын санхүүжилт олгох бүрд дараах албан бичгүүдээр хүргүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр албан бичиг
- Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 26 дугаар албан бичиг
- Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 38 дугаар албан бичиг
- Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 50 дугаар албан бичиг

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.
2. Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг журмын дагуу зарцуулсан байна.
3. Зардлын гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна.

**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 72 дугаар бичгээр тайлангийн төсөлтэй танилцаж санал нэг байгаагаа илэрхийлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:



Ч.МӨНХТОГТОХ

АУДИТОР:



Т.ЗОЛОО

ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



А.НАНЖИДМАА

М.БАТ-АМГАЛАН

